



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090
Утас: 7059 2494 Факс: (976) 7059 2494
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2024.10.21 № 02/1342

танай _____-ны № _____-т

Захирамж хянасан тухай

Тус сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар улиралд батлан гаргасан нийт 36 захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянаж үзэхэд доорх зөрчлүүд илэрч байна.

1.“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын ага хэмжээ, худалдаа үйлчилгээний төв ажиллахыг түр хориглох тухай” А/78 дугаар захирамжид үндэслэсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг 288 дугаар зүйл гэж бичсэнийг зөвтгөх,


2.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” Б/16 дугаар захирамжид Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасныг үндэслэх,

Захирамжлалын баримт бичгийг стандартын дагуу боловсруулж гаргасан эсэхийг хянан үзэхэд дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

А/76, А/82 дугаар захирамжаар баталсан хавсралтын хуудас бүрийг баталгаажуулаагүй,

Иймд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичгийн стандарт болон Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу баримт бичгээ боловсруулж гаргахыг зөвлөж байна.

Таны батлан гаргасан нийт 36 захирамжийн 4 буюу 11.1 хувь нь (үг, үсгийн болон давтан гаргасан алдааг зөрчилд тооцоогүй болно) зөрчлийн шинж байдлыг агуулж байх тул тухайн шийдвэрийн төслийг боловсруулсан албан хаагчдад танилцуулж, зөрчилтэй шийдвэр дахин гаргахгүй байхад анхаарах, шинэчлэн батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон, хүчингүй болсон хууль тогтоомжийг тухай бүр судлан гаргасан алдаа дутагдлыг залруулж зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тус хэлтэст 5 хоногийн дотор нотлох баримтын хамт мэдэгдэж, цаашид баталж буй шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлж ажиллана уу.



Дундговь аймгийн засаг даргын тамгын газар
Хууль, эрх зүйн хэлтэс
Хэлтсийн дарга
Лувсанням Баярсайхан
2024-10-21 18:25:41